



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/313

Хэрлэн сум

Хүүхдийн эрхийг хамгаалах Олон Улсын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 5 дугаар хуралдааны 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийн эрхийг хамгаалах Олон Улсын өдрийг “Хүүхэд, хайр, ирээдүй” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэхэд 14,616,200 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын “Ирээдүйн эзэд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ зардлаас олгохыг аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Жаргалсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ

